

GET IT ON
Google Play

Download on the
App Store

BDSec

БиДиСЕК ҮЦК
ХУВЬЦААТ КОМПАНИ
www.bdsec.mn

ЖИЛИЙН ТАЙЛАН 2020

ТУЗ-н даргын ИЛГЭЭЛТ

Эрхэм хүндэт хувьцаа эзэмшигчид, харилцагчид,
хамтран ажиллагсад аа,

Та бүхэнд “БиДиСЕК ҮЦК”ХК-ийн 2020 оны жилийн тайланг танилцуулж байгаадаа таатай байна. Өнгөрсөн онд дэлхий даяар Ковид-19 цар тахал гарч, нөхцөл байдал хүнд байсан хэдий ч манай компани үйл ажиллагаагаа хэвийн явуулж, багагүй амжилтыг гаргаж ажиллалаа.

2019 онд харилцагчиддаа шинээр толилуулсан цахим үйлчилгээг улам сайжруулж, цогц онлайн арилжааны платформ, аппликэйшнийг санал болгосноор хөл хорионы үед ч бүхий л төрлийн үйлчилгээгээ харилцагчиддаа саадгүй хүргэж байна.

Андеррайтерын үйл ажиллагааны хувьд 2020 онд 6-р сард “Бодь даатгал”ХК-ийн хувьцааг олон нийгэд санал болгон амжилттай арилжиж, 5,3 тэрбум төгрөгийн санхүүжилтийг татан төвлөрүүлсэн бөгөөд “Эрдэнэ ресурс девелопмент”ХК-ийн нийт хувьцааг МХБ-д бүртгүүлснээр давхар бүртгэл бүхий компанийн хувьцаа хоёр биржийн хооронд чөлөөтэй шилжин бүртгүүлэх боломжтой болоод байна.

Брокерын үйл ажиллагааны хувьд харилцагчийн тоогоо 59,918 данс шинээр нээж, харилцагчийн тоогоо 27,3%-аар нэмэгдүүлж, МХБ-д хийгдсэн нийт арилжааны 24,9%-ийг дангаар гүйцэтгэсэн байна. Сахо банкаар дамжуулан хэрэгжүүлдэг гадаад арилжааны хэмжээ 3 дахин нэмэгдэж, харилцагчийн тоо 2 дахин нэмэгджээ.

Хэдийгээр 2021 онд цар тахлын аюул бүрэн арилаагүй, эдийн засгийн нөхцөл бүрэн сэргээгүй байгаа боловч, манай компанийн хувьд харилцагчиддаа хүргэх үйлчилгээгээ улам бүр чанаржуулж, зах зээлд шинэ шинэ бүтээгдэхүүнийг санал болгон гаргаж, хөрөнгө оруулалтын бүтцээ шинэчлэн сайжруулсан амжилт бүтээл дүүрэн жил болно гэдэгт итгэлтэй буйгаа илэрхийлэхэд таатай байна.

Хүндэтгэсэн,

Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дарга,
Б.Лхагвадорж

Б.Лхагвадорж
ТУЗ-ийн дарга



Агуулга

Компанийн ерөнхий мэдээлэл	i
Компанийн үйл ажиллагаа	ii
2020 оны онцлох үйл явдал	iii
Нэгдсэн санхүүгийн тайлан	iv



Түүхэн замнал

1991

Баян Дөхөм брокерын пүүс Зуунмод хотод байгуулагдсан.

2000

Засгийн газрын бондын томоохон дилер болсон.

2005

СЗХ-оос андеррайнтерын үйлчилгээ үзүүлэх эрх авч, анхны IPO амжилттай хийсэн.

2006

Олон нийтэд нээлттэй цорын ганц ҮЦК болсон.

2007

2006 онд төрсөн 50,000 гаруй хүүхдүүдэд "Женко Тур Бюро" ХК-ийн хувьцааг үнэ төлбөргүйгээр эзэмшүүлсэн.

2012

Монголын хөрөнгийн биржийн арилжааны 91%-ийг дангаар гүйцэтгэж түүхэн амжилт тогтоов.

2017

Монгол улсын ХЗЗ-д хийгдсэн хамгийн том М&А болох АПУ ХК болон "Эвэргрийн Инвэстмэнт" ХХК-ийн нэгдлийг амжилттай гүйцэтгэсэн.

2018

Монгол улсын анхны давхар бүртгэл (Cross-listing) –ийг амжилттай гүйцэтгэсэн.

2020

Бодь Даатгал ХК-ийн андеррайтер-аар ажиллаж 5.3 тэрбум төгрөгийг амжилттай татан төвлөрүүлэв.



Эрхэм зорилго

Үндэсний үйлдвэрлэлийг хөрөнгө оруулалт, санхүүгийн цогц үйлчилгээгээр дэмжих, олон улсын стандартад нийцсэн санхүүгийн зах зээлд

Зорилтууд



Богино хугацаанд

Гадаад Харилцааг Өргөжүүлэх, үнэт цаасны арилжааг идэвхжүүлэх, Компанийн боловсон хүчнийг чадваржуулах, ХОЗҮ-г өргөжүүлэх



Дунд Хугацаанд

Үндэсний томоохон үйлдвэрлэгчдийг дэмжих, Олон улсын хөрөнгийн зах зээлд үйл ажиллагаа явуулах, МХЗЗ-д оролцогчдын хүрээг нэмэгдүүлэх.




Урт Хугацаанд

Олон улсын стандартад нийцсэн үйл ажиллагаа, Үндэсний томоохон хувьцаат компаниудыг шинээр бий болгох



Компанийн тухай

Бүтэц, зохион байгуулалт



Компанийн тухай

Төлөөлөн Удирдах Зөвлөл



Б.ЛХАГВАДОРЖ ТУЗ-ИЙН ДАРГА

БИДИСЕК ҮЦК ХК-ИЙН ТЭРГҮҮН ДЭД ЗАХИРАЛ

Иргэний хаярьялалал: Монгол
Төрсөн он: 1976
Боловсрол: Дээд, Нефтийн инженер
ХЗЗ-д ажилласан туршлага: 15 жил



Д.ДАЯНБИЛГҮҮН ЕРДИЙН ГИШҮҮН

БИДИСЕК ҮЦК ХК-ИЙН ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

Иргэний хаярьялалал: Монгол
Төрсөн он: 1976
Боловсрол: Дээд, Бизнесийн эдийн засагч
ХЗЗ-д ажилласан туршлага: 16 жил



Н.БАТГЭРЭЛ ЕРДИЙН ГИШҮҮН

БИДИСЕК ҮЦК ХК-ИЙН ДЭД ЗАХИРАЛ

Иргэний хаярьялалал: Монгол
Төрсөн он: 1974
Боловсрол: Дээд, Гадаад албаны ажилтан
ХЗЗ-д ажилласан туршлага: 16 жил



ULUC BINGOL ЕРДИЙН ГИШҮҮН

ИМПЕРА КАПИТАЛ -ИЙН ДЭД ЗАХИРАЛ

Боловсрол: Дээд, Лондонгийн Бизнесийн сургууль
2012-одоог хүртэл: Турк дэх хөрөнгө оруулалтын сан “Импера Капитал”-ын дэд захирал
2008-2011: Гаранти Банк-д Банк хамтрагч байгууллага, улсын эрдслийн удирдлагын хэсгийн ахлагч



Б.АМАРСАНАА ХАРААТ БУС ГИШҮҮН

ЗАХИРАЛ, ХЭРЭЭЖИ ХХК

Иргэний хаярьялалал: Монгол
Төрсөн он: 1977
Боловсрол: Дээд, Гадаад албаны ажилтан
Маркетингийн чиглэлээр ажилласан туршлагатай

Компанийн тухай

Төлөөлөн Удирдах Зөвлөл



Д.АМГАЛАНБАЯР

ХАРААТ БУС ГИШҮҮН

ЗАХИРГААНЫ МЭРГЭЖИЛТЭН, MSM ХХК

Иргэний хаярьялалал: Монгол
Төрсөн он: 1975
Боловсрол: Дээд, Эдийн засагч
ХЗЗ, уул уурхай, худалдааны салбарт ажилласан туршлагатай



Б.ЭНХБАЯР

ХАРААТ БУС ГИШҮҮН

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ, EXE GROUP

Иргэний хаярьялалал: Монгол
Төрсөн он: 1980
Боловсрол: Дээд, Эдийн засагч
ХЗЗ, санхүүгийн чиглэлээр ажилласан туршлагатай



HITOSHI TANI

ХАРААТ БУС ГИШҮҮН

ЕРӨНХИЙЛӨГЧ, EXE GROUP

Иргэний хаярьялалал: Япон
Төрсөн он: 1954
Боловсрол: Дээд, Эдийн засагч



JAMES PASSIN

ХАРААТ БУС ГИШҮҮН

ЗАХИРАЛ, ПОРТФЕЛЬ МЕНЕЖЕР, FIREBIRD MANAGEMENT LLC

Иргэний хаярьялалал: АНУ, Нью Йорк хот
Төрсөн он: 1971
Боловсрол: Дээд, Эдийн засагч
ОУ-ын ХЗЗ-д ажилласан туршлагатай



ТУЗ-ИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

МЕНЕЖЕР, БИДИСЕК ҮЦК ХК

Иргэний хаярьялалал: Монгол
Төрсөн он: 1995
Боловсрол: Дээд, ОУ-ын эдийн засгийн харилцаа
ХЗЗ-ийн чиглэлээр ажилласан туршлагатай

2020 ОНЫ ОНЦЛОХ АЖЛУУД:



Монголын Хөрөнгийн Биржийн нийт арилжааны **24.9%**-ийг дангаараа бүрдүүлэв.




2020 онд нийт харилцагчийн тоо **59,918**-р өсөв.




Бодь Даатгал ХК-ийн IPO-г амжилттай хийж, **5.3** тэрбум төгрөг таган төвлөрүүлэв.



Гадаад арилжааны дүн **3** дахин нэмэгдэв.



BACK OFFICE, FRONT OFFICE-ийн системийг шинэчлэв.



Онлайн БРОКЕРЫН ЦОГЦ үйлчилгээг нэвтрүүлэв.



Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг онлайнаар зохион байгуулав.

Брокерийн үйлчилгээ

“БидиСЕК ҮЦК” ХК нь харилцагч, хөрөнгө оруулагчиддаа Монголын Хөрөнгийн Зах Зээл дээрээс үнэт цаас худалдах, худалдан авахад нь зуучлалын үйл ажиллагааг түргэн шуурхай гүйцэтгэсээр ирсэн ба үйлчилгээгээ улам ойртуулж илүү чанартай үзүүлэхийг үргэлж зорин ажилладаг.




2020 онд гарсан COVID-19 цар тахлаас үүдэн компани нь харилцагч нартаа хүргэх цахим үйлчилгээг улам сайжруулж, хамгийн цогц онлайн арилжааны платформыг санал болгон ажиллаж байна.

Мөн компанийн харилцагчид болон олон нийгэд үнэт цаасны үнэ ханшийн үнэн бодит мэдээ, мэдээлэл, судалгаа, шаардлагатай бусад заавар зөвлөгөөг



Салбарын үйл ажиллагаа



Компани нь Санхүүгийн Зохицуулах Хорооноос салбарын үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрөлтэй Орхон аймаг, Дархан-Уул аймаг, Төв аймаг, Улаанбаатар хотын төв салбаруудаар дамжуулан тогтмол үйл ажиллагаагаа харилцагч, хөрөнгө оруулагч нартаа хүргэж ажиллаж байна.





Онлайн брокер

Харилцагчид нь вэб хөтчөөр болон гар утас, компьютер ашиглан ХААНААС Ч, ХЭЗЭЭ Ч Монголын Хөрөнгийн Биржийн арилжаанд оролцох, захиалгаа илгээх, дансны үлдэгдэл харах, гүйлгээ хийх боломжтой.




БиДиСЕК ҮЦК ХК-ийн онлайн арилжааны систем, гар утасны аппликэшин нь дараах цэсийг багтаасан:

- Хяналтын самбар
- Дансны хуулга
- Гүйлгээний түүх
- Үлдэгдэл
- Өгөөжийн тооцоолол
- Ашгийн тооцоолол
- Миний багц /демо арилжаа/
- Арилжаа



“БиДиСЕК ҮЦК” ХК нь сүүлийн 9 жилийн байдлаар нийт зах зээл дээрх үнэт цаасны арилжааны 8-91%-ийг дангаар гүйцэтгэсэн



Брокерийн үйлчилгээ

Арилжааны үзүүлэлт


Хоёрдогч:		МХБ:		Анхдагч:	
МХБ:	78.2 тэрбум	МХБ:	101.31 тэрбум	МХБ:	30.14 тэрбум
БиДиСЕК:	15.96 тэрбум	БиДиСЕК:	25.13 тэрбум	БиДиСЕК:	10.73 тэрбум
	20.41%		24.81%		35.60%

“БиДиСЕК ҮЦК” ХК нь 2020 онд нийт арилжааны 24.81%-ийг дангаар хийж гүйцэтгэсэн байна.


Харилцагчид

“БиДиСЕК ҮЦК” ХК нь 2020 онд нийт 59,918 данс шинээр нээснээр нийт харилцагчдын тоо 280,000-д хүрсэн. Монгол улсын хөрөнгийн зах зээл дээрх нийт харилцагчдын 22% нь манай компаниар үйлчлүүлж байна.


Дотоод харилцагчид



Нийт харилцагчид




Гадаад харилцагчид



■ "БиДиСЕК ҮЦК" ХК ■ Бусад

Данс нээсэн тоо



Данс нээсэн тоо (салбараар)



Институциональ харилцагчийн албын үйл ажиллагаа


Гадаад арилжаанд зуучлах үйлчилгээ



Компани нь Санхүүгийн Зохицуулах Хорооноос 2017 оны 05 сарын 11-ний өдөр “Гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах үйл ажиллагаа”-ны зөвшөөрөл авснаар дотоодын харилцагчиддаа олон улсын зах зээл дэх үнэт цаасны арилжаанд оролцох бололцоог бүрдүүлээд байна. Компани нь тус үйлчилгээний хүрээнд олон улсын тэргүүлэгч онлайн брокер Саксо Групптэй хамтран ажиллаж байна.



Судалгаа анализ



Бид гадаад болон дотоод хөрөнгө оруулагч, томоохон харилцагчиддаа зориулан Монголын эдийн засаг болон хөрөнгийн зах зээл, хувьцаат компаниуд-ын талаарх мэдээлэл, тайлан, судалгааг олон улсын стандартад нийцүүлэн бэлтгэж, харилцагчиддаа тогтмол хүргэн ажиллаж байна.

Судалгаа шинжилгээний онолын аргачлалыг Монголын хөгжиж буй зах зээлд тохируулан өөрчилж, бусад хөгжиж буй улсуудын компаниудтай харьцуулалт хийж, өөрсдийн дүгнэлтийг өгч хөрөнгө оруулагчдын шийдвэр гаргалтад дэмжлэг үзүүлдэг.

Хөрөнгө оруулагчдийн уулзалт

COVID-19-ын улмаас гадаадын хөрөнгө оруулагч нар нь Монгол Улсад айлчлан ирэх боломжгүй болсонтой холбоотойгоор бид “conference call”-уудыг Монголын Хөрөнгийн Биржид бүртгэлтэй томоохон хувьцаат компаниудтай амжилттайгаар зохион байгуулсан

Андеррайтерын үйл ажиллагаа

“БидиСЕК ҮЦК” ХК нь Монгол Улсын эдийн засгийн хөгжил, үйлдвэржилтэнд хувь нэмэр оруулахуйц үндэсний үйлдвэр, компаниудад хөрөнгө оруулалт татахад нь бүхий л талаар дэмжин ажиллаж байгаа ба Монголын хөрөнгийн зах зээл дээр шинээр гаргасан хувьцаа болон бондын андеррайтераар ажиллаж, энэ чиглэлээр ихээхэн туршлага хуримтлуулсан.


Бид 2020 онд доорх төслүүдийг андеррайтерийн үйл ажиллагааны хүрээнд хэрэгжүүлсэн:

IPO

МХБ-Д ХУВЬЦААНЫ БҮРТГЭЛ ХИЙЛГЭСЭН



5.3 ТЭРБУМ ТӨГРӨГ ТАТАН ТӨВЛӨРҮҮЛЭВ



Онцлог:

Стратегийн ач холбогдол бүхий таван толгой нүүрсний ордод үйл ажиллагаа эрхэлдэг, Монгол улсын тэргүүлэгч компаниас гадна хамгийн олон хувьцаа эзэмшигчтэй компани гэдгээрээ онцлогтой.

Хэрэгжүүлсэн төсөл:

2019 оны 12 сард СЗХ бүртгэхээр зөвшөөрсөн. 2020 оны 06 сард IPO анхдагч зах зээлд санал болгох ажиллагааг гүйцэтгэн 5.32 тэрбум төгрөгийг татан төвлөрүүлсэн.

Investment advisory

БИРЖ ХООРОНД ХӨРВӨХ БОЛОМЖ



Хэрэгжүүлсэн төсөл:

СЗХ-ны шинэчлэгдсэн журмын дагуу ЭРДН ХК-ийн нийт хувьцааг МХБ-д бүртгүүлэх ажиллагааг гэрээний дагуу гүйцэтгэсэн. Үүний үр дүнд бирж хооронд хөрвөх боломж бүрдэв.

ДАВУУ ЭРХИЙН ХУВЬЦАА ХОЗУ



Хэрэгжүүлсэн төсөл:

Ачит Ихт ХХК-ийн охин компани Ачит Зэс ХК-иар дамжуулан гаргасан 3 жилийн давуу эрхийн хувьцаанд хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ үзүүлэн ажиллаж байна.

Back office-ийн үйл ажиллагаа

Санхүүгийн Зохицуулах Хорооны 2020 оны 01 сарын 29-ний өдрийн “29 дугаар” тогтоолоор Монголын Хөрөнгийн Биржийн арилжааны төлбөр тооцооны горимийг T+2, DvP (Delivery versus Payment) горимд шилжүүлж, Үнэт цаасны компаниуд нь харилцагчийн мөнгөн хөрөнгийн гүйлгээг Номинал дансаар дамжуулан гүйцэтгэх, Клирингийн гишүүн болох шаардлага бий болсон.

Энэхүү нийт Хөрөнгийн Зах Зээлд хийгдэх системийн өөрчлөлттэй холбоотойгоор “БиДиСЕК ҮЦК” ХК нь 2020 оны 05 сарын 01-ний өдрөөс Монголын Үнэт Цаасны Клирингийн төвийн “Клирингийн шууд гишүүн”-р элсэж харилцагчийн арилжааны мөнгөн төлбөр тооцоог Номинал дансаар дамжуулан гүйцэтгэх болсон.

Номинал дансаар төлбөр тооцоо гүйцэтгэх, харилцагчдын мөнгөн хөрөнгийн гүйлгээг цаг тухайд нь хийх, хянах үйл ажиллагааг Компанийн Backoffice алба хариуцан гүйцэтгэж байна.



01. Клирингийн шууд гишүүн болов

ҮЦКлирингийн төвийн холбогдох шаардлагыг хангаж “Клирингийн шууд гишүүн” болов.



02. Номинал данс гэрээ, журам

Номинал дансны гэрээ, дотоод журам шинэчлэн боловсруулж, баталсан.



03. Системийн шинэчлэл,

T+2,DvP горимоор төлбөр тооцоог гүйцэтгэх ажилыг системээр хийж эхэлсэн.




04. Номинал данс нээх

Арилжааны банкуудад номинал дансыг нээж, харилцагчид сонголтыг бий болгов.



НОМИНАЛ ДАНС-ны үйл ажиллагааны газар дээрх **ШАЛГАЛТ** Мөнгө угаах, террозмын эсрэг үйл ажиллагааны газар дээрх **ШАЛГАЛТ**



Монгол улс саарал жагсаалтаас гарах ФАТФ-ын газар дээрх шалгалтын **УУЛЗАЛТАНД** оролцов




Комплайнсын **СУРГАЛТАНД** хамрагдав.

Үйл ажиллагаа


Нийт арилжааны дүн

/тэрбум төгрөг/



2020 оны нийт арилжааны дүн

/сая төгрөг/



280,000+
ХАРИЛЦАГЧ


59,918
ДАНС НЭЭСЭН

Санхүүгийн үзүүлэлт

Хөрөнгийн бүтэц




Эх үүсвэрийн бүтэц



Санхүүгийн үзүүлэлт


Орлого, зарлага, цэвэр ашиг

/тэрбум төгрөг/




Ашигт ажиллагааны шинжилгээ

ROA



ROE



Онлайн Захиалгын Систем

<https://reg.bdsec.mn>





ЖИЛИЙН ТАЙЛАН 2020


БидиСЕК ҮЦК ХК

Андеррайтер, Брокер, хөрөнгө оруулалтын зөвлөх,

Холбоо барих

 +976-75551919

 info@bdsec.mn

 БидиСЕК ҮЦК ХК, Залуучуудын өргөн чөлөө, 8-р хороо,
Сүхбаатар дүүрэг, Улаанбаатар хот, Монгол Улс